



МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 93

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.8 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Онцгой байдлын байгууллагын бүсийн ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг хангаж, бүсийн төвийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвт тусгаж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга (хошууч генерал Г.Ариунбуян)-д даалгасугай.

3.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Шадар сайдын 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 51 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД



С.АМАРСАЙХАН

0025100829

Монгол Улсын Шадар сайдын
2025 оны 16 дугаар сарын 12-ны
өдрийн 93 дугаар тушаалын
хавсралт

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН БҮСИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь гамшиг, томоохон осол, аюулт үзэгдэлтэй тэмцэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны удирдлага, зохицуулалтыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулах, бүсийн онцгой байдлын байгууллагуудын төлөвлөлт, бэлтгэл, бэлэн байдал, харилцан ажиллагааг хангах, бүсийн төв, түүний харьяа байгууллагуудын удирдлагын эрх, үүргийг тодорхойлоход оршино.

1.2. Онцгой байдлын байгууллагын бүсчилсэн зохион байгуулалт, удирдлагыг Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д нийцүүлэн тогтооно.

1.3. Энэхүү журамд зааснаас бусад үйл ажиллагаа нь бүсийн удирдлага, зохицуулалтад хамаарахгүй.

Хоёр. Бүсийн удирдлага, зохицуулалтын үндсэн зарчим

2.1. Бүсийн удирдлага, зохицуулалтад дараах зарчмыг баримтална.

2.2.1. гамшиг, томоохон осол, аюулт үзэгдлийн үеийн удирдлага зохицуулалтыг бүсийн харьяа онцгой байдлын байгууллагын чадавхад түшиглэн шуурхай, оновчтой зохион байгуулах;

2.2.2. бүсийн хэмжээнд онцгой байдлын байгууллагын харилцан ажиллагааг нэгдмэл удирдлага, зохион байгуулалтаар хангах;

2.2.3. орон нутгийн онцгой байдлын байгууллагын хуулиар олгосон бүрэн эрхэд хамаарах асуудалд хөндлөнгөөс үл оролцох.

Гурав. Бүсийн зохион байгуулалт, удирдлага

3.1. Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх анги, салбараас бусад орон нутгийн салбар, нэгжийг Хангайн, Баруун, Хойд, Төвийн, Зүүн, Говийн, Улаанбаатарын гэсэн 7 бүсэд хувааж, гамшиг, томоохон осол, аюулт үзэгдлийн үеийн удирдлага зохицуулалтыг бүсчилсэн тогтолцоогоор зохион байгуулна.

3.2. Хангайн бүсэд Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймаг; Баруун бүсэд Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймаг; Хойд бүсэд Булган, Орхон, Хөвсгөл аймаг; Төвийн бүсэд Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймаг; Зүүн бүсэд Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймаг; Говийн бүсэд Говьсүмбэр, Дорноговь, Дундговь,

Өмнөговь аймаг; Улаанбаатарын бүсэд нийслэл Улаанбаатар хот ба түүний дагуул хотууд хамаарна.

3.3.Хангайн бүсийн төв-Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газар, Баруун бүсийн төв-Ховд аймгийн аймгийн Онцгой байдлын газар, Хойд бүсийн төв-Орхон аймгийн Онцгой байдлын газар, Төвийн бүсийн төв-Дархан-Уул аймгийн Онцгой байдлын газар, Зүүн бүсийн төв-Дорнод аймгийн Онцгой байдлын газар, Говийн бүсийн төв-Өмнөговь аймгийн Онцгой байдлын газар, Улаанбаатарын бүсийн төв-Нийслэлийн Онцгой байдлын газар байна.

3.4.Бүсийн удирдлагыг бүсийн төвийн Онцгой байдлын газрын дарга /цаашид “Бүсийн захирагч” гэх/ хэрэгжүүлнэ.

3.5.Бүсийн захирагчаар онцгой байдлын байгууллагад удирдах албан тушаалд 5-аас доошгүй жил ажилласан ахлах офицер, түүнээс дээш цолтой алба хаагчийг томилно.

3.6.Бүсийн төв нь шуурхай ажиллагаа, зохицуулалт, төлөвлөлт, бэлэн байдал, холбоо, зарлан мэдээлэл, тайлан, дүн бүртгэл зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэх штабтай байх бөгөөд штабын бүтэц, орон тоо, төсвийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга батална.

3.7.Бүс нь харьяа аймгуудын Онцгой байдлын газрын дарга нараас бүрдсэн бүсийн зөвлөлтэй байх бөгөөд зөвлөлийг бүсийн захирагч тэргүүлнэ.

3.8.Бүсийн зөвлөлийн ажиллах журмыг зөвлөлөөр хэлэлцэж, бүсийн захирагч батална.

3.9.Бүсийн захирагч нь энэ журамд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд бүсийн нэр бүхий тэмдэг, хэвлэмэл хуудас /хавсралт №1, 2/ хэрэглэнэ.

Дөрөв. Бүсийн захирагчийн эрх, үүрэг

4.1.Бүсийн захирагч бүсийн хэмжээнд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1.гамшиг, ослын эрсдэлийг үнэлэх, эрт хариу арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх, гамшигтай тэмцэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг мэргэжлийн нэгдсэн удирдлагаар хангах, зохион байгуулах, хяналт тавих;

4.1.2. гамшиг, ослын үед ажиллах бүсийн харьяа онцгой байдлын байгууллагын хүч хэрэгсэл, ар тал, хангалт, холбоо зохион байгуулалт, эрт зарлан мэдээллийн тооцоог гаргах, төлөвлөх, тодотгох, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх арга, тактик боловсруулах;

4.1.3.гамшиг, ослын нөхцөл байдалтай холбогдуулан бүсийн харьяа онцгой байдлын байгууллагын хүч хэрэгслийг гаргах, хуваарилах, харилцан ажиллагааг зохицуулах;

4.1.4.гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдал, хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Онцгой байдлын ерөнхий газрыг мэдээллээр хангах;

4.1.5.гамшиг, аюулт үзэгдэл, осол, ажилласан хүч хэрэгсэл, ар тал, хангалтын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх;

4.1.6.гамшиг, ослын хор уршгийг арилгах, шуурхай удирдлага зохицуулалтаар хангах асуудлаар бүсэд хамаарах орон нутгийн удирдлага, Онцгой комисстой харилцах;

4.1.7.гамшиг, ослын нөхцөл байдалтай холбогдуулан бүсийн харьяа онцгой байдлын байгууллагуудыг албаны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх;

4.1.8.бүс нутгийн байгаль цаг агаар, газар зүйн онцлогт тохируулан алба хаагчдыг дулааны болон хүйтний улирлын хувцсанд шилжүүлэх;

4.1.9.бүс нутгийн гамшгаас хамгаалах чадавх, бэлэн байдлыг дээшлүүлэх чиглэлээр санал боловсруулж, дээд шатны удирдлагад танилцуулах;

4.1.10.нэгдсэн арга хэмжээ, гамшгаас хамгаалах дадлага сургуулийг төлөвлөх, зохион байгуулах;

4.1.11.Онцгой байдлын ерөнхий газраас өгсөн чиглэлийн дагуу хил залгаа улс, орны ижил чиг үүрэг бүхий байгууллагатай харилцах, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

4.1.12.эрхлэх асуудлын хүрээнд тушаал, шийдвэр гаргах.

4.2. Бүсийн хил дамнасан гамшгийн нөхцөл байдлаас шалтгаалж удирдлага зохицуулалтыг зэргэлдээ бүс рүү шилжүүлэх асуудлыг тухайн бүсийн удирдлага болон Онцгой байдлын ерөнхий газрын гал түймэр, гамшгийн асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга нарын саналыг үндэслэн Онцгой байдлын ерөнхий газрын дарга шийдвэрлэнэ.

Тав. Бүсийн Онцгой байдлын газар, хэлтсийн эрх, үүрэг

5.1.Онцгой байдлын газар, хэлтсүүд нь бүсийн хэмжээнд дараах эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллана:

5.1.1.орон нутгийн түвшинд хуулиар хүлээсэн эрх, үүргийг бие дааж хэрэгжүүлэх;

5.1.2.гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, бүсийн гамшигтай тэмцэх нэгдсэн төлөвлөлтийг хэрэгжүүлэх;

5.1.3.харьяалах нутаг дэвсгэрт тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээ, хэрэгжүүлсэн арга хэмжээг бүсийн төвд, шаардлагатай тохиолдолд Онцгой байдлын ерөнхий газарт тухай бүр шуурхай мэдээлэх;

5.1.4.бүсийн төв болон онцгой байдлын газар, хэлтсүүдийг шаардлагатай, үнэн зөв мэдээллээр хангах;

5.1.5.бүсийн захирагчаас гамшгаас хамгаалах чиглэлээр гаргасан шийдвэр, өгсөн үүрэг, чиглэлийг хэрэгжүүлэх, тайлагнах;

5.1.6.гамшигтай тэмцэх ажиллагаанд байгууллагын хүч хэрэгслийг хуваарилан оролцуулах, харилцан дэмжлэг үзүүлэх;

5.1.7.гамшгийн хор уршгийг арилгах ажиллагаанд оролцоход шаардагдах зардлыг хариуцах.

Зургаа. Бусад

6.1.Бүсийн төвийн үйл ажиллагааг Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга шууд удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллана.

6.2.Бүсийн төв нь бүсийн үйл ажиллагааны тайлан мэдээг улирал бүр нэгтгэж, Онцгой байдлын ерөнхий газарт ирүүлнэ.

6.3.Онцгой байдлын ерөнхий газар нь бүсийн үйл ажиллагааг хагас, бүтэн жилээр үнэлж дүгнэнэ.

---oOo---